



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/13

Баян-Адарга сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дүгээр зүйлийн 66.1, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 46, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг Даргын тамгын газрын авто машин , тоног төхөөрөмжид хэрэглэгдэх авто бензин, дизелийн түлш болон шатах тослох материал худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Хосбаяр (Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч)

Гишүүд: М.Отгонжаргал (Ерөнхий боловсролын сургуулийн
нийгмийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: М.Нямдорж (Дуурлиг багийн засаг дарга)

2.Сумын Засаг даргын Тамгын газрын Төсвийн хөрөнгөөр хийгдэх нэр дурдсан ажлыг холбогдох хууль журмын хүрээнд зохион байгуулахыг үнэлгээний хорооны ахлагч (С.Хосбаяр)-т, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.ЖАГВАДОРЖ